



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/357

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 78 дугаар тогтоолоор баталсан "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн 7 дугаар зүйлийн 7.3.4.5 дахь заалт, Засаг даргын удирдлагын зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 22 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хос бичигтэн" арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн байгууллагуудын дунд "Хүмүүн бичиг - хүн бүрийн бичиг" уралдааныг зохион байгуулахад шаардагдах 1,660,000 (нэг сая зургаан зуун жаран мянга) төгрөгийг "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн батлагдсан зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, санхүүгийн зарцуулалтыг тайлагнаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

